



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 04 сарын 18 өдөр

Дугаар

A/108

Улаанбаатар хот


Худалдан авах ажиллагаа  
зохион байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Нийслэлийн 2019 оны төсөвт зохицуулалт, нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 2019 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 23/15 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Эрх шилжүүлэх тухай” А/137 дугаар захирамж, 2019 оны А/298 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.21 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/298 дугаар “Эрх шилжүүлэх тухай” захирамжийн 3 дахь заалтад зааснаар Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/137 дугаар “Эрх шилжүүлэх тухай” захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх авто зам, засварын ажлын жагсаалт”-ын 1, 2, 4, 5, 6, 8, 11 дэх хэсгийг хүчингүй болгосонтой холбогдуулан Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/48 дугаар “Үнэлгээний хороо байгуулах тухай” тушаалын 1 дэх зүйлд заасан 1, 2, 4, 5, 6, 8, 11 дэх ажлуудыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/298 дугаар “Эрх шилжүүлэх тухай” захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх авто зам, засварын ажлын жагсаалт”-ын 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12 дэх ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 48 дугаар байгуулагдсан Үнэлгээний хороонд даалгасугай.

3. Дээрх ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, зөвлөмжийг Нийслэлийн Авто замын хөгжлийн газарт хүргүүлж ажиллахыг Үнэлгээний хороо /Ц.Рэгзэдмаа/-нд үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



D:\Backup\_old\_pc\Work documents\doc 2019\Тушаал doc.docx

111С30С333

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2019 оны 04 сарын 18  
өдрийн тушаалын хавсралт



### ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Ц.Рэгзэдмаа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит дотоод хяналтын хэлтсийн дарга
Гишүүд	Э.Батжаргал	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит дотоод хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Д.Лувсанчимэд	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн
	Р.Дуламжав	Баянзүрх дүүргийн 15 дугаар хороо 74В-46 тоотод оршин суугч /иргэн/
Нарийн дарга	бичгийн П.Чойжилжав	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн.